


## 20

## Үйлдвэрийн ажлыг гэртээ хийх



Зарим эмэгтэйчүүд болон тэдний нөхөр нь гэрээ орхихгүй байхыг хүсдэг, аль эсвэл тэд мөнгө олонгоо гэр бүлээ асрахын тулд үйлдвэрийн ажлыг гэртээ хийдэг. Зарим ажилчид илүү их мөнгө олохын тулд нэмж гэртээ ажил авчирдаг. Заримдаа үйлдвэрийн эзэд зарлагаа багасгахын тулд эсвэл үйлдвэр нь хаагдсан учраас ажилчдаа албадан гэрт нь ажиллуулдаг.

Ажилчид олон цагаар гэртээ ажиллах үед үйлдвэрт ажилласнаас илүү олон төрлийн аюултай нүүр тулж байдаг. Гэрээр ажилладаг ажилтан нь ихэвчлэн бага цалин авдаг тул дарга нарын үүрэг хариуцлага болох байсан үйлдвэрлэлийн олон зардал хасагддаг:

- Сэнс болон хувийн хамгаалах хэрэгслүүд (хэрвээ тэд бүгдийг нь авсан бол);
- Гэрэл, цахилгаан;
- Ширээ, сандал, бас ажлын тавилгууд;
- Хог хаягдлыг зайлуулах;

- Хангамж, хэсгүүд болон хийгдэж дууссан бараа хадгалах агуулах;
- Үйлдвэр, гэр хоёрын хооронд хийх тээвэрлэлт.

Гэрээр ажилладаг ажилчид нь үйлдвэрийн ажилчдаас бага цалин авдаг ба үүнд мөн хүүхэд асрах зардал, гэрээс хол ажиллах үеийн хоол, үйлдвэр явах өдөр тутмын тээврийн зардал болон үйлдвэрийн ажилчдад заавал зарцуулагдах ёстой мөнгө зэрэг нь төлөгддөггүй байж болох юм.


## Хэрхэн

## Өөрийн бодит цалинг тооцоолох

Ажил хийхэд хэрэгтэй бүх зардлыг төлж дууссаны дараах өөрийн жинхэнэ олох мөнгийг буюу авах ёстой цалингаа тооц:


- **Хийсэн нэгж бүрт төлөх цалинг үржүүл.** Хэрвээ өөр өөр бараа өөрөөр бодогддог бол өөрөөр бод;

10-р сарын захиалга  
60 малгайтай цамц нэг  
бүр нь 20 цент  
 $60 \times 0,20 = 12\$$




- **Бараа материалын зардал, гэр бүлдээ эсвэл хөршдөө тусалсных нь төлөө хэдийг төлдөг, бас цахилгаан, ус болон ажиллаж байх үед гардаг бусад зардлыг хас.** Хэрвээ таны төлбөр сар бүр гардаггүй бол өмнөх сарын дүнгээс тооцоол. (Хэрвээ таны дарга энэ бүх зардалд мөнгө төлдөггүй бол суутгал хийж залруул.);

12\$ цалингаас хасах нь  
- 2,00 \$ -ыг материалд  
- 1,50 \$-ыг Мэрид тусалсан учир  
- 1,00 \$-ыг цахилгаан  
- 0,50 \$-ыг усанд  
= 7,00 \$ нийт



- Сар бүр болон хэдэн сар тутамд хэдий хэмжээний цалин авч байгаагаа **харьцуулан тооцоол.** Та яг хэдий хэмжээний цалин авч байгаагаа баттай мэдсэн бол даргаасаа үйлдвэрлэлийн зардалд нэмж мөнгө төлөхийг шаард.

Нэгдүгээр сар 8,50 \$  
Гуравдугаар сар 7,50 \$  
Зургадугаар сар 7,50 \$  
Аравдугаар сар 7,00 \$






**“Нэмэлт орлого олохын төлөө юу” эсвэл “амь зуухын” төлөө ажиллах уу?**

## Гэрээрээ ажил хийдэг ажилчид илүү олон цагаар ажилладаг

Гэрээрээ ажилладаг эмэгтэй ажилчид үйлдвэрийн ажилчдаас ч илүү их ажилладаг. Тэд хоол хийж, хүүхэд, гэр бүлийнхнээ асарч, хоол хүнс, ус, түлш худалдаж авах болон цуглуулахаас эхлээд бусад олон төрлийн ажлыг хийдэг. Үйлдвэрийн ажил хийнгээ гэр орон болон гэр бүлдээ санаа тавьж ажиллана гэдэг хийх ажлууд нь улам их нэмэгдэж, өдөрт илүү олон цагаар ажиллана гэсэн үг. Тэд ихэвчлэн үйлдвэрт хийх байснаас илүү олон цагаар ажилладаг.

Тэд хаана ч ажиллаж байсан, хэт их ажиллах нь үргэлж илүү их гэмтэл бэртэл, эрүүл мэндийн асуудал, стрессээс үүдэлтэй өвчин, хүнс тэжээлийн дутагдал болон бусад



асуудлыг үүсгэж байдаг. Энэ мэтчилэн хоёр дахин илүү ажиллаж байгаагаас үүсэх эрүүл мэндийн асуудлыг багасгахын тулд эрэгтэйчүүд ялангуяа гэр орон, гэр бүлээ асрах хэсгийг нь өөр дээрээ авч, гэр бүлээрээ энэ асуудлыг шийдэх арга замыг олж болох юм. Эрчүүд, хөвгүүд гэр орны ажил хийх чадварт суралцаж чадна.

## Бүхэл бүтэн гэр бүлээрээ ажиллаж болно

Ажил гэр лүү шилжсэн нь гэр бүлд маань бүхлээр нь нөлөөлсөн. Хэдийгээр нэг нь ажлаа гэртээ авчирч байгаа ч хийсэн нэгж бүр нь илүү мөнгө олж байдаг тул гэр бүлийн бүх гишүүд, бүр хүүхэд хүртэл ажилладаг. Нэг хүн үйлдвэрлэлийн нормыг ганцаараа хийх боломжгүй тул түүнд туслахын тулд бүхэл бүтэн гэр бүлээрээ ажиллах ёстой болдог. Ажил оройтож, шөнө дунд хүртэл хийдэг ч гэр бүлээрээ олон цаг ажилласны цалин авдаггүй.



Би хүүхдээ *надаг тусалсных нь төлөө мөнгө өгөх гэж хичээсэн. Би тэдний хийсэн ажил нь шударга цалинтай байх хэрэгтэй гэдгийг ойлгуулмаар байгаа ч цалин маш бага тул тэдэнд юу ч өгч чадахгүй л байна.*

## Ажлын аюул гэрт илүү их нэмэгддэг

Үйлдвэрийн ажлыг гэртээ хийхэд үйлдвэрт гардаг асуудалтай ижил асуудлууд гарна. Гэхдээ гэртээ ажиллах нь илүү аюултай. Гэрт ажлын орчин үүсгэхэд түүхий эд болон химийн бодисыг аюулгүй хадгалах хангалттай орон зай байдаггүй. Тэнд ихэвчлэн гэрэлтүүлэг, агааржуулалтын систем болон аюулгүй ажиллахад шаардлагатай цахилгааны холболт дутагдалтай байдаг. Мөн хэрвээ тэнд эрүүл мэндийн болон аюулгүй ажиллагааны асуудал байвал тэр нь гэр бүлийн хэн нэгэнд нь нөлөөлдөг.

## Гал

Түүхий эд нь гал тогоон дахь гал эсвэл зуухтай ойр байх, залгуур болон бусад халууны эх үүсвэрт (чийдэн, халаагч эсвэл тамхи) ойрхон байвал түлэгдэж болно. Бүр жижиг гал хүртэл хүртэл гэрт үйлдвэрээс хурдан тархаж, илүү амархан гал гардаг. Гэр орноо галын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд:

- Түүхий эд материалыг халуун, ил гал эсвэл цахилгааны эх үүсвэрээс хол байлга.
- Цахилгааны холболтуудыг хуурай байлга.
- Тоног төхөөрөмжийг хэрэглээгүй бол цахилгаанаас салга.
- Олон тоног төхөөрөмжийг нэг залгуурт залгаж зэрэг ажиллуулахаас зайлсхий.
- Химийн бодисын савыг сайтар таглаж, хэрэглээгүй үед үүсэх уурыг зайлуулах сайн агааржуулалттай байлга.
- Түргэн шатах материалын дэргэд болон гэртээ битгий тамхи тат.

Хэрвээ гэрт тань гал гарвал унтраах бэлтгэлтэй бай:

**Гал гарахад хүргэх аль нэг хүчин зүйлийг арилгах.** Гал гарахад ямар нэг материал, агаар (хүчилтөрөгч) хэрэгтэй байдаг. Жижиг галыг унтраахад эдгээр элементийн аль нэгийг нь зайлуулах хэрэгтэй. Хэрэв хоол хийх саванд гал гарвал түүнийг бүтээж агааргүй болгосноор гал унтрах болно.

**Галын хорыг шороо, элс болон усны савтай хамт ажлын хэсэгт гал гарах үед хэрэглэхээр бэлэн байлга.** Цахилгааны болон химийн бодисын галыг усаар биш, элс юм уу, шороогоор дарна. Даавуунд ассан галд ус болон галын хор хэрэглэ (Галын хорыг хэрхэн хийх талаар 288 дугаар хуудаснаас үзнэ үү.)

### Өөрийгөө хамгаал.

Хэрвээ та гал унтраах гэж байгаа бол заавал гарах шаардлагатай үед бэлэн байхын тулд үргэлж гал, хаалга хоёрын дунд бай. Утааг уушгинд оруулахгүйн тулд ам хамраа даавуу болон амны хаалгаар дар.



Гэр бүл, олон нийтийг гал гарах үед юу хийх ёстойд бэлтгэ:

Гэр бүлээ байшингаас хэрхэн гаргах, дараа нь хаана уулзаж, хэрхэн туслах талаар хэлэлцэж, галын аюулаас **зугтах дадлага хий**.

Өөрийн амьдардаг орчны **гал командын утасны дугаарыг бичиж** үүнийг бүх хүнд мэдүүл.


Гал гарвал, түүнээс гарахад туслахад дохио өгөх **нийтийн түгшүүрийн дохиог** шийдэж (төмөр таваг цохих гэх мэт) бусад хүмүүст үүнийг мэдэгд.

**Гал унтраахад хамтдаа ажилла**. Хаанаас ус, элс эсвэл бусад гал унтраах зүйлсийг авах, өөр өөр төрлийн галд юу хэрэглэхийг мэддэг бай.

## Химийн бодис

Гэрт хэрэглэж байгаа химийн бодис нь таны хоол, ус, бас агаарт орж болно. Ихэвчлэн хэрэглэгддэг цэвэрлэгч (уусгагч), цавуу зэргийн нь аль аль нь толгой эргэх, амьсгалын асуудал үүсэх, арьс болон нүд цочроох, хорт хавдар үүсгэх, бүүр үхэлд хүргэх хүртэл урт болон богино хугацааны эрүүл мэндийн асуудлыг үүсгэдэг. 8-р бүлэг. Химийн бодисын аюул, Хавсралт Б: Түгээмэл химийн бодис, материал хэсгүүдээс дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. Хэрвээ танд бодисын тухай ямар ч мэдээлэл олдохгүй бол тэдгээрийг аюултай гэж үзээрэй.

- Химийн бодист хүрэхийг хязгаарла. Өөрийн арьс болон нүднээс хол байлгахын тулд хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэ (18-р бүлгийг үз);
- Ажлын орчинд болон ажлаа хийж дууссаны дараа гараа үргэлж угаах хэрэгтэй ба арчсан давуу болон угаасан усыг өөр юунд ч бүү хэрэглэ;
- Химийн бодис хадгалахад гэрийн ямар ч савыг битгий хэрэглэ. Хэрвээ тэгэхээр бол бичигдсэн бүх хаяг шошгыг арилгаж, саван дээр химийн бодисын нэрийг бич. Саван дээр жишээлбэл “Аюултай”, “Хүрч болохгүй” гэх мэт тэмдэглэн бичсэн байхын зэрэгцээ ийм бичиг наасан, гэр бүлийнхэндээ аюултайг нь сануулахуйцаар байлгах хэрэгтэй;
- Химийн бодистой байсан савыг өөр зорилгоор хэзээ ч битгий хэрэглэ. Савыг маш сайн угаасан ч бай химийн бодис байсаар байдаг юм;



- Асгарч, гоожихоос сэргийлж химийн бодисын савыг бүтээж, мөн дундуурхан байлга;
- Химийн бодисыг хүүхэд хүрэхээргүй газар хадгал;
- Химийн бодисыг цоожтой шүүгээ эсвэл гадна амбаарт хадгал;
- Химийн бодисын ойролцоо идэж, ууж, тамхи татаж эсвэл хоол хийж болохгүй.

## Тоос

Хувцасны тоос болон жижиг утаснууд нь амьсгалын замын асуудлууд (141-142 дугаар хуудсыг үз) буюу харшил үүсэх, ханиалгах, арьсанд тууралт гарах (218-219 дүгээр хуудсыг үз) зэрэг асуудлын шалтгаан болдог. Зарим тоос нь харагдахгүй маш жижиг байдаг. Үүнээс өөрийгөө хамгаалахын тулд сайн агааржуулалтын системтэй байж (17-р бүлгийг үз) ам, хамраа халхлах нүүрний хаалт хэрэглэ. Нүүрний хаалт хэрхэн хийх талаар сурахыг хүсвэл 349-354 дүгээр хуудсыг үзнэ үү.

Хуримтлагдсан тоос нь ил задгай цахилгааны утсанд хүрч гал гарч болно. Тиймээс цахилгааны самбарыг хаалттай байлга.

## Хэт их ачаалах ба хэт олон цагаар ажиллах

Нэг төрлийн хөдөлгөөнийг хэт олон удаа хийж, бэртэл гэмтэл авч, өвдөхийг багасгая гэвэл:

- Түүхий эд, багаж хэрэгсэл зэрэг өөрт хэрэгтэй зүйлсээ ажлын талбайд ойр байрлуул. Олон дахин сунаж хөдлөх нь таны биеийг өвтгөх болно;
- Шуу, тохой, нуруу, хөл зэргээ ажиллах үедээ түшлэгтэй байлга. Хэрвээ ажиллаж байхад буюу ажлын дараа таны биеийн аль нэг хэсэг өвдөж байвал байрлалаа өөрчилж үз;
- Завсарлага ав. Ажлаасаа нүдээ холдуулж, бас биеэ хөдөлгөн сунгалт хийж ажлаасаа хол бай;
- Нурууны түшлэгтэй, тухтай сандал ав.

Бие эрхтнээ хэт ачаалах ба хэт олон цагаар ажиллахаас үүсэх асуудлын талаар 7-р бүлэг. Эргономик хэсгээс үзнэ үү.

## Дуу чимээ

Тоног төхөөрөмжийн тогтмол дуу чимээ нь ялангуяа хэт чанга бол таны сонсолыг гэмтэнэ. Дуу чимээ болон чихний бөглөө яаж хэрэглэх талаар 13-р бүлгээс үзнэ үү.

## Стресс

Стресстэй, сэтгэл түгшсэн эсвэл гунигтай мэдрэмж төрөх нь хэвийн үзэгдэл боловч ажлын болон гэрийн ачааллаас болж хэт ядарч, бас цөхөрч болно. Стресстэй байх нь зөвхөн тааламжтай бус байхаас гадна урт хугацаандаа цусны даралт ихсэх, толгой өвдөх, булчин чангарахад хүргэж, дархлааг муутгадаг. Стресс таны бие болон оюун санаанд муугаар нөлөөлөхийг багасгах боломжтой. 526-528 дугаар хуудсыг үз.

Манай гэрээлэгч захиалга дуусгахыг, нөхөр маань хоол идэхийг, ээж маань намайг эмнэлэг рүү явуулахыг, бас хүүхдүүд маань анхаарал халамж хүсэж байна. Гэвч ядаж л надад юу хийхийг минь шаардах ахлах байхгүй нь сайн хэрэг юм даа.



**Танд маш олон хийх зүйлс байхад та яаж өөрийн хэрэгцээндээ санаа тавих болж байна вэ?**

## Гэртээ ажилладаг бусад ажилчдаас дэмжлэг авах

Үйлдвэрийн ажлыг гэрээр хийх нь таныг маш их тусгаарлаж, бас эрч хүч, өрсөлдөх чадвартай байхыг шаарддаг. Дарга нар үйлдвэрийн зардлыг хямд байлгахын тулд энэ өрсөлдөөнийг дэмжиж байдаг.

Өөрийн ойр орчмоосоо гэртээ ажилладаг бусад ажилчдыг урьж, нийтлэг асуудлууд болон бие биенийхээ ололт амжилт, алдаа дутагдлыг хуваалцаж, илүү сайн нөхцөлийн төлөө хамтран ажиллаж, арга зам ол. Зарим гэрээрээ ажилладаг ажилчид нь зай талбай, багцаараа хямд байдаг нөөц, хүүхэд асрах үүрэг зэргээ хуваалцдаг. Баг болон хамтран ажилласнаар илүү том захиалга хийх, илүү сайн цалингаар хэлцэл хийх эсвэл бүр өөрөө өөртөө дарга болох боломжийг олгодог.



## Манай гэрээрээ ажилладаг ажилчдын баг

Би гэрээр юм оёж эхлэх үедээ манай ойр орчимд маш олон эмэгтэйчүүд гэртээ ажилладаг байсныг мэдээгүй юм. Тэгээд би ойр хавиараа явж ярилцахад ихэнх эмэгтэйчүүд нь үйлдвэрийн ажлыг гэртээ хийдэг эмэгтэйчүүд байсан. Эхэндээ тэд надтай ярилцахыг хүсдэггүй байсан ч ажлын талаар мэддэг хэн нэгэнтэй хуваалцахад үргэлж амархан байсан. Удалгүй бид тогтмол уулзаж өөрсдийн хүүхэд, гэрийн амьдрал, ажлын талаар ярилцдаг болсон.

Үүний дараа нэг эмэгтэй маань гэрт нь химийн бодисын цэвэрлэгчээс хэрхэн гал гарсан тухай болон гал гарах үед яах тухай, галаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ярилцсан юм. Нэг эмэгтэй хэрвээ гал гарсан тохиолдолд хэрхэн зугтах талаар хүүхдэдээ заасан тухайгаа тайлбарлав. Уулзалтын дараа би илүү аз жаргалтай болж, бас их зүйл сурч авсан юм.

Бидний тав нь хамтдаа цех байгуулж, манай байшинд хамт ажиллахаар шийдэв. Бусад нь ажиллаж байх үед бидний нэг нь хүүхэд харж байв. Бид бүгд хүүхэд харах эсвэл юм оёх ажлаасаа цалин авч орлогоо тэнцүү хувааж байв. Маш их ажилтай байх үед бидний зарим нь шөнөжин сууж хамтдаа оёдог байв. Ажил хэцүү байсан ч одоо бид тодорхой хэмжээний дэмжлэгтэй болсон.

Одоо манай нөхөр ачааны том машинтай болсон тул бид зуучлагчгүйгээр шууд үйлдвэрээс илүү том захиалга авах болсон билээ. Хэрвээ тэгэхээр бол бид шууд эзэнтэй нь цалин, түүхий эд болон хайч гэх мэт багаж тоног төхөөрөмжийн талаар тохиролцож, илүү их мөнгө олох боломжтой болсон юм. Манай гэрээрээ ажил хийдэг ажилчдын баг одоо өөрсдийн нөхцөлөө сайжруулахад бие биедээ тусалж, дэмжин илүү сайн зохион байгуулалтад орно гэдэгт би итгэж байна.

## Гэрээр ажиллагчид нь ажилтан гэж хүлээн зөвшөөрөгдөх ёстой

Гэртээ ажилладаг хүмүүсийг ажилтан гэж хүлээн зөвшөөрснөөр тэд орон нутгийн болон улсын хуулиар эрүүл мэндийн даатгал, жирэмсний халамж тэтгэмж, бас хөдөлмөрийн чадвар алдалт, гэмтэл болон ажилгүйдлийн нөхөн олговор зэрэг нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдах боломжтой болно.



### Гэрээр ажиллагчдын эрх



ОУХБ-ын гэрээр ажиллах ажлын тухай конвенц (№177)-д зааснаар гэрээрээ ажиллагчид нь эрүүл мэнд, аюулгүй байдлын болон хөдөлмөрийн хуулиудаар үйлдвэрийн ажилтан шиг хамгаалагддаг байх ёстой. Гэрээр ажиллагчдад байх ёстой зүйлс:

- Үйлдвэрчний эвлэлд нэгдэх эсвэл өөрсдийн үйлдвэрчний эвлэлийг байгуулах;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал нь хамгаалагдсан байх;

(үргэлжлэл)

**Гэрээр ажиллагчдын эрх** (үргэлжлэл)

- Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг хамгаалагдсан байх;
- Сургалтад хамрагдах боломжтой байх;
- Ялгаварлан гадуурхлын эсрэг хамгаалагдсан байх;
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмжид хамрагддаг байх;
- Нийгмийн даатгалд хамрагдсан байх.

Ажилчдын эрхийг дэмжих олон улсын байгууллага НҮБ, ОУХБ-ын үүргийг Хавсралт А-д тайлбарлав.

### Үйлдвэрчний эвлэл гэрээр ажиллагчдад эрхээ эдлэхэд нь тусалдаг

1980 онд Австралийн хувцасны компаниуд үйлдвэрийн ажилчдын оронд гэрээрээ ажиллагчдыг хөлслөх болсон юм. Австралийн нэхмэл, хувцас, гутлын үйлдвэрчний эвлэлүүд гэртээ ажиллагчид нь яг адил ажил хийж байгаа ч үйлдвэрийн ажилчдаас бага хөлс авдгийг олж мэдэв. Мөн түүнчлэн тэд ямар ч хөдөлмөрийн хуулиар хамгаалагдаагүй тул ажил олгогч нь ажлын муу нөхцөл байдлыг сайжруулах үүрэг хариуцлагаас мултарсан байв. Тиймээс гэрээр ажиллагчдыг үйлдвэрчний эвлэл нь дахин цуглуулахыг оролдсон юм. Гэвч тэдний ихэнх нь дарга нарын өөдөөс гомдоллохоос айж байв. Тэд ажлаа алдахыг хүсэхгүй байв. Учир нь тэдний ихэнхэд нь тэднийг дэмжих ямар нэг зүйл байхгүй ба англиар ярьдаггүй цагаачид байсан тул хэн ч тэдэнд итгэхгүй гэж бодож байлаа.

Үйлдвэрчний эвлэл гэрээрээ ажиллагчид, бас орон нутгийн хамтрагчидтай нийлж “шударга хувцас” хөдөлгөөнийг эхлүүлсэн юм. Энэ үндэсний болон олон улсын хөдөлгөөнөөр маш олон төрлийн олон нийтийн байгууллагууд хамтдаа гэрээрээ ажиллагчдын эрхийг дэмжив. Эмэгтэйчүүдийн баг, сүм хийдүүд болон олон нийтийн байгууллагууд үйлдвэрчний эвлэлд нэгдэж, байгууллагууд руу утасдан гэрээрээ ажиллагчдын эрхийг хүндэл гэж хэлж байв. Тэд компаниуд, дэлгүүрүүдийн гадна радио болон сониноос хүмүүсийг урьж, арга хэмжээ зохион байгуулж байв. Хэвлэл мэдээллийнхний анхааралд орсноор тэд хэрэглэгчдийн өмсдөг хувцсыг хийж байгаа ч шударга цалин өгөхгүй байна гэдгийг олон нийтэд харуулж чадав. Хэрэглэгчдийн дэмжлэгтэйгээр үйлдвэрчний эвлэл

нь гэрээрээ ажиллагчдыг хөдөлмөрийн хуулиар хамгаалуулж, шударга цалин авахыг нь баталгаажуулж хэлэлцээр хийсэн юм. Гэрээрээ хувцас хийдэг ажиллагчдыг одоо Австралийн нэхмэл, хувцас, гутлын үйлдвэрчний эвлэлүүд хамгаалдаг юм.

